

Юань бүс нутагт тархаж буй логик шалтгаан, Монгол улс дахь Юань урсгалд дүн шинжилгээ хийх нь

М.Бүрэнжаргал

Товч агуулга: Мөнгөний мөн чанар ба арилжааны өртөг (Transaction Costs) бол юань хил дамнан эргэлтэнд орох гол нөхцөл нь болж өгдөг. Өөрчлөлт шинэчлэлт, нээлттэй бодлогын хэрэгжилт нь юани идэвхжих үндсэн шалтгаан, гол хүчин зүйл нь болж өгөө. 2009 оноос хойш Хятадын засгийн газраас хил дамнасан худалдаанд юаниар тооцоо хийх туршилтын зарчмыг хэрэгжүүлсний үр дүнд хил дамнасан юаний гүйлгээ шинэ шатанд гарав. Монгол улсад юань урсан орж ирж буй гол арга зам нь хоёр орны арилжааны банкны хамтын ажиллагаан дээр суурилж байна.

Түлхүүр үгс: Юань, Мөнгөний хил дамнасан эргэлт, Монгол улс

* * *

Нэг. Мөнгөний мөн чанараас юанийн хил дамнасан логик шалтгааныг шинжлэх нь



Валют мөнгө бол аж ахуй нийгмийн үндсэн хэлбэр байдаг бөгөөд мөнх хөдлөхүй чанар бол мөнгөний оршихуй үндсэн төлөв байдал болдог. Мөнгөний хөдлөнгүй шинж чанар нь юанийн хил давах боломжийг бий болгож түүхийн онцгой нөхцөлд юань хөрш оронд урсан оржээ. Хятад ба хөрш орны хоорондох эдийн засгийн харилцааны явцад юанийн хил давж эргэлдэж байгаа үзэгдэл нь Хятадын дотоод дахь эд баялагийн өсөлт буюу түүний гадагш бялхан гарсны илрэл болох юм. Мөн дэлхийн таваарын худалдаа

*М.Бүрэнжаргал, БНХАУ-ын ӨМӨЗО-ы ӨМИС-ийн Монгол Судлалын сургуулийн багш, доктор.

хийгээд соёлын солилцоог дамжиж юань дотоодын валют байснаа аажмаар гадаад валют болж хөгжсний бодит илрэл юм.

Юань хил дамнан эргэлдэж эхэлсэн тэр үеэс эхлээд түүний үндсэн ажиллагаа хийгээд шинж чанарт гүн гүнзгий өөрчлөлт гарчээ. Юань нь энгийн үндэстний валют байснаа бүс нутгийн чанартай цаашлаад олон улсын чанартай валют болсон байна. Учир нь үндэстний валют тус орныхоо хилээс давж бусад улс буюу бүс нутагт эргэлдэх болсоноор яг л хүмүүс айлчлан зочлохдоо үргэлж хамгийн гоё цэвэр хувцсаа өмсдөг шигээр тухайн валютийн уг бие нь билэг тэмдгийг төлөөлөгч шинж чанартай болохоор түүний аливаа үйл ажиллагаа эзэмшигч улс орныхоо үзэл суртал ба эрх сүрийг харуулж байдаг. Өөрөөр хэлбэл юанийн хил давж эргэлдэж байгаа энэ үзэгдэл нь Хятадын эдийн засгийн өөрчлөлт нээлттэй байх үзэл суртлыг бий болгосны билэг тэмдэг болж бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн явц дахь Хятадын өвөрмөц байр суурийг билэгдэж үзүүлжээ. Гуч гаруй жилийн туршид өөрчлөн байгуулж нээлттэй байлгаж, энэ урт хугацааны туршид эдийн засгийн дундаж өсөлт 9% өссөнөөр, Хятадын эдийн засаг аж үйлдвэржилтийн болон мэдээллийн технологийн шинжлэх ухааны хөгжил зэрэгцэн оршсон хөгжлийн үе шатанд оржээ. Ингэж урт хугацааны эдийн засгийн их хэмжээний өсөлтийг бий болгосон 1,3 тэрбум хүн амтай нэгэн том эдийн засгийн цогц болсны улмаас хөрш орны зах зээлд юань тархах болжээ.

Бүс нутагт дахь юаний тархалтын гол хөдөлгөгч хүч нь дараах гурван зүйл юм. Үүнд дотоодын эдийн засгийн хөгжил, хөрш орны эдийн засгийн хөгжил ба олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааг ахиулах үйл явц болно. Дотоодын эдийн засгийн хөдөлгөгч хүч гэдэг нь Хятадын эдийн засгийн хурдацтай өсөлт, геологийн тогтоцын давуу тал, тогтвортой бөгөөд нээлттэй болж байгаа мөнгө санхүүгийн орчин юм. Хөрш орны эдийн засгийн нөлөөлөх хүчинд нөөц баялагийн харилцан нөхвөрлөх чанар, хөрш орнуудын зах зээлийн нээлттэй байдал, мөнгө санхүүгийн системийн өөрчлөлт зэргийг хэлнэ. Хятад ба хөрш орнуудын хоорондох хамтын ажиллагааны хөдөлгөгч хүчинд хилийн арилжааны хөгжил, хилийн аялал жуулчлалын хөгжил, шууд хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, хил дамнасан арилжаанд юаниар

тооцоо хийх болсон зэрэг асуудал багтана.

Хоёр. Хилийн худалдаа, арилжааны өртөг ба юанийн бүс нутаг дахь чадавхийн өсөлт

Бодит практикаас харахад хилийн арилжаа бол юанийн тархалтыг ахиулсан хамгийн гол эдийн засгийн хүчин зүйл ажээ. Юанийн бүсжилтийн тархацаас харахад юань нь Хятадын эх газраар хиллэж байгаа ихэнхидээ хөгжиж байгаа улс орнуудын хилээр орж тухайн оронд эргэлдэж байгаа. Тэдгээр хөрш орнуудын хамтын ажиллагааны онцлог нь газарзүйн байршлын хувьд Хятадтай хиллэж хүмүүнлэг ба геологийн талаар харилцан төстэй хөгжиж байгаа улс орнууд юм. ХХ зууны 80-аад оны сүүлчээс эхлээд Хятад болон хөрш орнуудын хилийн харилцаа маш хурдтай хөгжжээ. Хятадын газарзүйн байршлийн өвөрмөц давуу тал гадаад эдийн засгаа хөгжүүлэхэд онцгой давуу нөхцлийг бүрдүүлж өгчээ. Нэн ялангуяа ХХ зууны 90-ээд оноос Дорнод, Дунд, Зүүн хойд Азийн хөрш орнуудтай хийх хилийн худалдаа өдөр ирэх бүр улам хөгжиж байна. Энэ хугацаанд ихэнх хөрш орнууд дотоод эдийн засгийн бүтэц тэнцвэртэй бус, гадаад валютийн хадгаламжийн ноцтой дутагдал, санхүүгийн зах зээл тогтворгүй байдал, дээр нь Азийн санхүүгийн хямралын сөрөг нөлөө зэргээс болж хилийн арилжааны хоёр улсын хооронд хэрэглэх валют мөнгөний өртгийг тогтвортой байлгахын тулд мөн цаг орон зайн өртгийг хэмнэх шаардлагаас болж юаниар арилжааны тооцоог хийдэг байв. Зарим хөрш орон эдийн засгийн бүтцийн зохисгүй байдлаас шалтгаалж урт хугацааны турш дотоодын эдийн засаг нь хөгжиж чадахгүй байв. Бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар доошилсон нь тэдгээр улсын экспортлох хэмжээг багасгаж гадаад гуйвуулга ихээр дутагдан, мөнгөн гүйлгээний байгууллага гадаад гуйвуулга шаардагчдын хэрэгцээг хангаж чадахгүй болж гадаад гуйвуулгын өртөг ихээр нэмэгджээ. Жижиг улс орнуудын эдийн засгийн орчин дахь хөрөнгө мөнгөний дутагдал тэдний дотоод мөнгөн гүйлгээний зах зээл тогтвортой байхад муугаар нөлөөлж ард иргэд тухайн орны үндэсний валютийн ханшны тогтвортой байдалд итгэлгүй болжээ. Арилжааны өртгийг багасгахын тулд хүмүүс хил дамжих аялал жуулчлал ба хөрөнгө оруулалтын ажиллагаандаа юанийг хэрэглэх болжээ. Үүний улмаас нэн их

хэмжээний юань хил дамнан урсах болж түүнийг дагалдан юанийн бүс нутагт эргэлдэх хөгжлийн хандлага бий болжээ.

Азид санхүүгийн хямрал үүссэнээс хойш Азийн зарим жижиг улс орнуудын үндэсний валютуудад ноцтой цохилт өгөхийн зэрэгцээ юань нь тогтвортой бөгөөд ханш нь өссөөр байгаа учир дэлхий нийтийн хөрөнгө эзэмшигчид хүлээн зөвшөөрөх болжээ. Хятадын гадаад худалдаа тасралтгүй хөгжихийн дагуу юанийн солилцоонд хэрэглэх өөрийн өртөг нь багасч юаниар солилцох арилжааны хүрээ хэмжээ ихсэх тусмаа үр ашиг өгөөж нь нэмэгдэж юанийн бүс нутгийн чанартай валютийн чадавхийг тасралтгүй дээшлүүлэв. Хураангуйлбал хилийн чанадад юанийн эргэлтийн байдал бий болсон нь зах зээлийн мөнгөний мөн чанар ба хилийн арилжааны хөгжилд харилцан нөлөө үзүүлсний үр дүн мөн. Геологийн байршил хилийн худалдаа хийгээд арилжааны өртөгийг багасгах зэрэг хүчин зүйл юанийн бүс нутгийн валютын чадавхийг дээшлүүлсэн үндсэн шалтгаан болно гэж үзэж байна.

Гурав. Юанийн Монгол улсад урсан орж байгаа гол замууд

2009 оноос хойш Хятадын засгийн газраас хил дамнан арилжаанд юаниар тооцоо хийх туршилтын зарчмуудыг хэрэглэх болсноор хил дамнан юанийн үйлчилгээ шинэ үе шатанд орж таваарын арилжаанаас гадаад шууд хөрөнгө оруулалтанд юанийг хэрэглэж эхэлсэн. 2012 онд Хятадын төв банкны Хөх хот дахь салбар банкны судалгааны групп Эрээн хотын хилийн боомтоор жишээлэн Монгол улсад эргэлдэж байгаа юаний хэмжээ 5.48 тэрбум орчим гэж тооцоолсон байна¹. Юанийн Монголд урсан орж байгаа гол замыг доорх хэдэн төрөлд ангилж болно.

1. Хоёр орны Арилжааны банкуудын хоорондох юаниар тооцоолох зам

2002.02 сард Хятадын Хөдөө Аж Ахуйн банкны Өвөр Монголын салбар банк болон Монголын Худалдаа Хөгжлийн банк хоорондоо Хятад, Монголын анхдагч юанийн дансыг нээсэн. 2011 онд ӨМӨЗО

¹ Хятадын төв банкны Хөх хот дахь салбар банкны судалгааны групп "Хятад, Монголын хооронд юань бэлэн мөнгө хэлбэрээр хил дамнан урсаж байгаа байдал". Өвөр Монголын санхүү судлал сэтгүүл, 2012.№3.

ба Монгол улсын хоорондох юанийн тооцоо 9,8 тэрбум юань хүрчээ. Үүнээс таваарын арилжаанд юаниар тооцоо хийсэн хэмжээ 9,2 тэрбум, ӨМӨЗО-оос Монгол улсад экспортлосон нийт өртгийн 51%-ийг эзэлжээ². Монгол улстай хил дамнасан юанийн тооцоо нилээд их байгаагийн шалтгаан нь Нэгд, юаниар тооцоо хийх нь Хятад, Монголын хилийн харилцаанд өргөнөөр хэрэглэгдэх болсон. Хоёрт, юанийн өртөг нь тогтвортой байх ба Монголын хэрэглэгчдэд хүлээн зөвшөөрөгдөж байгаа. Гуравт, Монголд юаниар тооцоо хийхэд хялбар болж байгаа зэрэгтэй холбоно. 2013 оны эх болтол Өвөр Монголын нийт 7-н Хятадын хөрөнгө оруулалттай банк болон Монголын бүх 14 арилжааны банк хоорондоо нийт юанийн 38 харилцах дансыг нээсэн.

2. Хоёр орны арилжааны банк хоорондох дансны мөнгөний харилцаа хийгээд банкны картгийн үйлчилгээний зам

2009.09 сард Хятадын Гадаад Гуйвуулгын Менежментийн Яам Монгол улстай арилжааны банкны дансны мөнгийг тооцоолох болон худалдаалахыг зөвшөөрч нэг жилд 600 сая ам.долларын дотор өмнөх үйл явдлыг явуулахаар болсноор Хятад, Монгол хоёр орны банкны хооронд юань чөлөөтэй эргэлдэх шинэ замыг тавьж өгчээ.

2010.01 сард Хятадын банкуудын холбоо болон Монголын Голомт банк хамтарч юанийн стандарт картыг үйлчилгээнд гаргажээ. Энэ бол Хятадын банкны холбооноос анх удаа Гонконг болон Макао-гоос өөр оронд гаргасан юанийн карт болно. 2012 онд Монголд нийт 46000 гаруй банкны холбооны стандарт картыг гаргасан бөгөөд түүний дунд юаниар тооцоо хийх банкуудын холбооны карт 12822 байж бүх картын 27.71% -ийг эзэлжээ. 2012 онд Монголын гаргасан банкуудын холбооны картаар дэлхийн хэмжээнд 160 сая юань гүйлгээ хийгдсэн байна³.

² Хятадын төв банкны Хөх хот дахь салбар банкны судалгааны групп “2011 онд ӨМӨЗО-ы хил дамнасан юанийн ажлын үзүүлэлтийн тайлан” 2012.

³ Юн Вэнзень “Монгол улсад юань эргэлдэж байгаа байдал”. Өвөр Монголын санхүүгийн судлал сэтгүүл, 2013.№6.

3. Хятад, Монголын хооронд юанийг бэлэн мөнгө хэлбэрээр хил дамнуулан зөөвөрлөх зам

2002 онд Эрээн хот дахь Хятадын Хөдөө Аж Ахуйн банк ба Монголын Худалдаа Хөгжлийн банк хамтарч их хэмжээний юанийг бэлнээр ачиж тээвэрлэж хил давуулах хэлэлцээрт гарын үсэг зуржээ. Энэ нь юанийг бэлнээр хил гаргаж тээж зөөвөрлөх төрийн бодлогын үндсийг тавьж өгчээ. Дараа нь мөн хоёр орны хооронд юанийг бэлнээр хилээр оруулж гаргах холбогдох дүрэм зарчмуудыг тогтоосон нь хоёр орны хамтын ажиллагаанд чухал нөлөө үзүүлжээ.

Хоёр орны хооронд данс нээсэн арилжааны банкуудын бэлэн юаний шаардлага өдөр ирэхүйеэ ихэссэнээр бэлэн мөнгө тээвэрлэх тоо тасралтгүй нэмэгджээ. 2010 онд Монголын талын арилжааны банк ӨМӨЗО-ы арилжааны банкуудаас нийт 99 удаа бэлэн юань тээвэрлэж нийт ойролцоогоор 2,671 тэрбум юань хүрчээ⁴. 2012 оны эцэс болоход Монголын 11 арилжааны банк Өвөр Монгол дахь 5-н Хятадын хөрөнгө оруулалттай банкнаас нийт 726 удаа бэлэн юань тээвэрлэсэн ба нийт хэмжээ нь 16,887 тэрбум юаньд хүрчээ⁵.

4. Хувь хүн бэлэн юань биедээ авч гарах зам

1993 оноос эхлээд Хятадын Төв банкнаас хувь хүн биедээ 20000 юань авч хилээр гарахыг зөвшөөрсөн нь бэлэн мөнгө хилээр дамжин авч гарч орох хууль зүйн суурийг тавьжээ. Нэг талаар бодит амьдрал дунд хүмүүс хилийн боомтоор нааш цааш зорчихыг дагалдан юань хил дамжин урсаж байна. Нөгөө талаар зарим худалдаачид хууль бусаар биедээ юань авч гарч байна. Урт хугацааны турш хувь хүний биедээ авч яваа бэлэн юанийн хэмжээ нилээд их байж бараг нийт хил гарсан бэлэн мөнгөний хэмжээний 47%-ийг эзэлж байна.⁶ Холбогдох материалыг үндэслэвэл хилийн гаднах зах зээл дэхь юанийн эрэлт хууль ёсны дагуу бүрэн хангагдахгүй байгаа гэсэн шалтгаанаар хил дамнансан далд эдийн засгийн ажиллагааны дагуу нилээд хэмжээний

⁴ Хятадын төв банкны Хөх хот дахь салбар банкны судалгааны групп “Хятад, Монголын хооронд юань бэлэн мөнгө хэлбэрээр хил дамнан урсаж байгаа байдал” Өвөр Монголын санхүүгийн судлал сэтгүүл, 2012.№3.

⁵ Юй Вэнзень “Юанийн Монгол улсад эргэлдэж байгаа байдал”. Өвөр Монголын санхүү судлал сэтгүүл, 2013.№6.

⁶ Сүлд “Монгол улсад юанийг хэрэглэж байгаа байдал” Шинжилгээ судалгаа сэтгүүл, 2014.№1.

юань хилийн гадна гарч байгаа. 2008 онд холбогдох тоо баримтаас гадуур Монгол улсад хил дамжин урсан орж байгаа юаний хэмжээ бараг 0.723 тэрбум буюу нийт урсан орж байгаа юаний хэмжээний 35.62 % болно.⁷ Хуульд нийцсэн эдийн засгийн ажиллагааны дагуу юанийн хил дамнан урсахыг нэг алхмаар ахиулж хоёр орны хоорондох худалдаа эдийн засгийн ажиллагааг нэн эрүүлээр хөгжүүлэх нь чухал юм.

⁷ Жоу Жихуа “Монгол улс руу чиглэсэн юанийн урсгалд хийсэн судалгааны тайлан”, Өвөр Монголын санхүү судлал сэтгүүл. 2008. 11.